



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 03 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг 2024 оны сүүлийн хагас жилийн байдлаар танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

НЭГ.ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрийн зорилтын гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд чиглэж байгаа эсэхийг тогтоох, хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР.АРГА ЗҮЙ

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг "Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.", Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт "хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах" заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Тус хөтөлбөрийн дэд зорилт бүрийн хэрэгжилтийг дээрх журмын 6.2.2-т заасан "бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлох" аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ яам, агентлаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хяналт-шинжилгээний үндсэн суурь мэдээлэл болгон ашигласан болно.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН


Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны сүүлийн хагас жилд 34.0 хувийн хэрэгжилттэй байна.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлант он буюу 2024 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлээр үнэлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Тус хөтөлбөрийн хэрэгжилт 34.0 хувь байгаагаас хэрэгжилтийг бодлогоор нь ангилж үзвэл Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого хамгийн өндөр буюу 40.6 хувь,

Бүсчилсэн хөгжлийн бодлого хамгийн бага буюу 25.2 хувийн хэрэгжилттэй байна. (График 1)



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хэрэгжилт үр дүнтэй гэж үнэлэгдсэн 3 зорилт байгаагаас Бүсчилсэн хөгжлийн бодлогын, Хүний хөгжлийн бодлогын, Эдийн засгийн бодлогын тус бүр 1 зорилт байна.

Нийт 4 бодлогын хүрээнд хугацаа болоогүй 199 зорилт байна.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 620 дэд зорилтоос 3 буюу 0,5 хувь нь үр дүн гарсан, 73 буюу 11.8 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 241 буюу 38.9 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай байгаа бол 104 буюу 16.8 хувь нь үр дүнгүй байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, бодлогоор, үр дүнгийн ангиллаар, хувиар, 2024 он

№	Бодлогын нэр	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь						ХБ	Хэрэгжилт хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0		
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	92	1	1	2	7	26	21	34	25.2
2	Хүний хөгжлийн бодлого	152	1	10	11	14	51	23	42	36.4
3	Эдийн засгийн бодлого	222	1	6	18	42	48	45	62	34.0
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	154	0	2	23	20	33	15	61	40.6
	Нийт	620	3	73		241		104	199	34.0
	Дүнд эзлэх хувь	100.0	0.5	11.8		38.9		16.8	32.0	
9	Үр дүнгийн ангилал		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй				

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, чиглэл тус бүрийн хэрэгжилтийн хувь, үр дүнтэй болон үр дүнгүй зорилтыг дараах байдлаар харуулав. Үүнд:

Бүсчилсэн хөгжлийн бодлого

Энэ бодлогын хүрээнд 4 чиглэлийн 92 зорилтын хэрэгжилт 21.6 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт, хувиар

Зорилго	Чиглэл	Зорилт (тоо)	Хэрэгжилт (хувь)
Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ.	1.1.Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт	34	33.0
	1.2.Бие даасан эдийн засаг бүхий улсын зэрэглэлтэй хот, дагуул хот	11	27.0
	1.3.Бүсийн төрөлжсөн хөгжил	31	11.0
	1.4.Орон нутгийн хөгжил	16	15.5
Нийт		92	21.6

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 1 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 3 зорилт 70-90 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 33 зорилт 30-50 буюу эрчимжүүлэх шаардлагатай, 21 зорилтын хэрэгжилт 0.0 хувь буюу үр дүнгүй байгаа бол 34 зорилтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйгээс дүгнэгдээгүй.

Хүний хөгжлийн бодлого

Энэ бодлогын хүрээнд 4 чиглэлийн 152 зорилтын хэрэгжилт 33.0 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Зорилго	Чиглэл	Зорилт (тоо)	Хэрэгжилт (хувь)
Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ..	2.1.Чинээлэг монгол хүн	68	38.0
	2.2.Эрдэм боловсролтой монгол хүн	41	39.0
	2.3.Эрүүл монгол хүн	18	30.0
	2.4.Баялагтаа эзэн монгол хүн	25	25.2
Нийт		152	33.0

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 1 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 21 зорилт 70-90 буюу тодорхой үр дүнд хүрсэн, 65 зорилт 50-30 буюу эрчимжүүлэх шаардлагатай, 23 зорилтын хэрэгжилт 0.0 хувь буюу үр дүнгүй байгаа бол, 42 зорилтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйгээс дүгнэгдээгүй.

Эдийн засгийн бодлого

Энэ бодлогын 4 чиглэлийн 152 зорилтын хэрэгжилт 42.8 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Эдийн засгийн бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Зорилго	Чиглэл	Зорилт (тоо)	Хэрэгжилт (хувь)
Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамж бүхий ногоон хөгжлийг цогцлооно.	3.1. Эдийн засгийн эрх чөлөө	18	55.0
	3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын орчин	23	40.0
	3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал	154	29.6
	3.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт	27	46.9
Нийт		222	42.8

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 1 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 24 зорилт 70-90 буюу тодорхой үр дүнд хүрсэн, 90 зорилт 30-50 буюу эрчимжүүлэх шаардлагатай, 45 зорилтын хэрэгжилт 0.0 хувь буюу үр дүнгүй, 62 зорилт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйгээс дүгнэгдээгүй.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого

Энэ бодлогын 4 чиглэлийн 154 зорилтын хэрэгжилт 40.6 хувь байна. Чиглэл тус бүрийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хэрэгжилт, чиглэлээр, хувиар

Зорилго	Чиглэл	Зорилт (тоо)	Хэрэгжилт (хувь)
Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Монгол үндэсний үнэлэмжийг нэмэгдүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад бодлогын нээлттэй, олон тулгуурт зарчмыг баримтална.	4.1. Хүний эрх, эрх чөлөө	33	48.2
	4.2. Авлигагүй засаглал	39	30.6
	4.3. Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл	19	43.3
	4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм	63	40.3
Нийт		154	40.6

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Уг бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн 25 зорилт 70-90 хувь буюу тодорхой үр дүнтэй үр дүнд хүрсэн, 53 зорилт 30-50 буюу эрчимжүүлэх шаардлагатай, 15 зорилтын хэрэгжилт 0.0 хувь буюу үр дүнгүй, 61 зорилт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүйгээс дүгнэгдээгүй.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилт дунджаар 34.0 хувь байна.

Тус хөтөлбөрийн 620 зорилтоос 3 буюу 0.5 хувь үр дүнтэй, 73 буюу 11.8 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 241 буюу 38.9 хувь эрчимжүүлэх шаардлагатай, 104 буюу 16.8 хувь үр дүнгүй хэрэгжсэн байна. (Хүснэгт 6).

Хүснэгт 6.ЗГҮАХ-ийн хэрэгжилт, үнэлгээний ангиллаар, хэрэгжилтийн хугацаагаар

Үнэлгээний ангилал		Нийт зорилтын тоо	Дүнд эзлэх хувь
Үр дүнтэй	100%	3	0.5
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	73	11.8
	70%		
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	241	38.9
	30%		
Үр дүнгүй	0%	104	16.8
Хугацаа болоогүй	ХБ	199	32.0
Нийт		620	100.0

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

- Зорилтын хэрэгжилт үр дүнгүй байгаа шалтгаан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй хугацаа алдсан, хөтөлбөрт тусгагдсан зорилтууд утга агуулгын хувьд давхардсан, тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв батлагдаагүй, мөн тендер шалгаруулалт, гэрээ байгуулах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой байна.

- Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар баталсан хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр уг хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн эсэх, үр дүн гарсан эсэхийг нэгдсэн дүнгээр тооцох боломжгүй байна. Учир нь тус хөтөлбөрийн үр дүнг тооцох мэдээллийн эх сурвалж болон мэдээлэл цуглуулах давтамж гэх мэт үзүүлэлтүүд нь тухайн оны 4 сараас хойш нэгтгэгдэж гардаг бөгөөд зарим үзүүлэлт нь 2-3 жил тутамд судалгааны үр дүнгээр гардаг байна.

Иймд уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайланг холбогдох хуульд заасан хугацаанд буюу УИХ-д өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө (2 дугаар сарын 01-ний өдрийн дотор) УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн байх шаардлага нь хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнахад хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлохдоо урьдчилан судалгаа, шинжилгээнд үндэслэн нөөцийн хязгаарлалт болон үүсэж болзошгүй эрсдэлийг харгалзан

үзэж, тогтоосон хугацаанд биелүүлэх боломжтой, бодитой, хэмжигдэхүйц зорилго, зорилтыг тусгах;

- Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан зорилт бүрийг коджуулж, цахим системээр боловсруулах, батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн тогтолцоог бий болгох;

- Бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх зорилго, зорилт тус бүрийн урьдчилсан судалгааг бүрэн хийж, хэрэгжүүлэх ажлын хүрээг зөв тодорхойлж, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшинг оновчтой төлөвлөх, зорилт, арга хэмжээг үндсэн хариуцагч байгууллага нь шалгуур үзүүлэлтийн дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаж, шалтгаан түүний үр дагаврыг тодорхойлж хэвших;

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөвлөлтийг төлөвлөлтийн хугацаатай уялдуулж баталдаг болох эрх зүйн зохицуулалт хийх;

- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг тайлагнах цаглабарын зөрүүг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулах.

---oOo---